



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/469

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 4.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 30 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн "Хамтарсан ажлын хэсэг байгуулах тухай" А/11 дүгээр тушаалаар бусад газар, хэлтсийн мөрдөгч нар орон нутагт ажилласантай холбогдуулан гарсан зардалд 6,000,000 (Зургаан сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 6,000,000 (Зургаан сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох баримт бичгийн бүрдүүлбэрийг хангаж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогчид хүлээлгэж өгөх ажлыг зохион байгуулахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа (А.Алтанцоож)-д үүрэг болгосугай

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН